

Маргааны товч:

Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын 2023 оны А/113 дугаар захирамжаар Дорнод аймгийн Халхгол сумын Ташгай багийн нутагт байрлах 1631,2 га газрыг “Соёмбобуудай” ХХК-д шилжүүлж, 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн байна.

Мөн Засаг даргын 2022 оны өдрийн А/73 дугаар захирамжаар газрын хэмжээг 1629.88 га болгож, 4 нэгж талбарт хуваан 6 жилийн хугацаатай эзэмшүүлжээ.

Нэхэмжлэгч “Буйрнуур халхгол нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн” НҮТББ-аас “2022 оны А/73 дугаар захирамжийг хүчингүй болгуулах, 2013 оны А/113 дугаар захирамжаар “Соёмбобуудай” ХХК-д олгосон газар эзэмших эрхийн гэрчилгээг цуцлахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгож, газар эзэмших эрхийг цуцлуулах”-аар маргажээ.